



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

СУМДАД ЭРХ ШИЛЖҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛСЭН ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ НЬ ХУУЛЬ, ЖУРМЫН ШААРДЛАГАД НИЙЦЭЭГҮЙ,
ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ АЖЛУУДЫН ГЭРЭЭГ СУНГАЖ АЖИЛЛААГҮЙ, ХЭРЭГЖИЛТЭД
ТАВИХ ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ЗАА-2025/21-12-ШТА



Улиастай хот

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn

Аудитын менежер Х.Болдбаатар
Утас: 7046-3783, Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Пүүжмаа
Утас: 99080797, Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn

Аудитор Л.Гансүлд
Утас: 88161818, Цахим хаяг: gansuldl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
www.open.audit.mn хаягаас үзнэ үү

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР..... 4

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ..... 4

**АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ
МЭДЭГДЭЛ..... 5-6**

**БҮЛЭГ 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨЛТИЙН
ШААРДЛАГАД БҮРЭН НИЙЦҮҮЛЖ ТӨЛӨВЛӨХГҮЙ БАЙНА..... 6-10**

- 1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 30.4 хувь нь аймгийн богино болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаагүй төлөвлөгдсөн байна
- 1.2 Төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлээгүй, ИТХ-ын төлөөлөөгч нар тойрогтоо хөрөнгө оруулалт хийхийг урьтал болгож төсвийг баталж байна.
- 1.3 Зураг төсөлгүй, зураг төсөлд магадлал хийгдээгүй төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд баталдаг, зарим төсөл арга хэмжээний зураг төсвийг ажлыг гүйцэтгэх явцад боловсруулсан байна

**БҮЛЭГ 2. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАН ҮЗЭХ, ДАХИН
ҮНЭЛГЭЭ ХИЙХДЭЭ ХУУЛЬ, ЖУРМЫГ МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА
..... 10-14**

- 2.1 Эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт нь хууль, журмын шаардлагад нийцээгүй, баримт бичгийн бүрдүүлэлт дутуу, хяналт тавих хариуцлага сул байна.
- 2.2 Тендерийн баримт бичиг, өгөгдлийн хүснэгтийг боловсруулахдаа хэт ерөнхий байдлаар боловсруулж байна.
- 2.3 Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгож ажиллах шаардлагатай байна.

**БҮЛЭГ 3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ
САНХҮҮЖҮҮЛСЭН Ч, АШИГЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД ХӨРӨНГИЙГ ДАНС БҮРТГЭЛД
БҮРЭН ТУСГАЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА..... 14-21**

- 3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн байна.
- 3.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй ажлуудын гэрээг дүгнэж, сунгах арга хэмжээ авч ажиллаагүй байна.
- 3.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байна.
- 3.4 Ажлыг хүлээж авахдаа комиссын дүгнэлтээр үүрэг даалгаврын биелэлт өгөөд үүрэг даалгаврынхаа биелэлтийг эргээд хянадаггүй алдаа давтан гарсаар байна.
- 3.5 Гэрээний үнийн дүн нь 1,418.9 сая төгрөг бүхий 6 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

ДҮГНЭЛТ.....	22
ЗӨВЛӨМЖ:.....	23
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	24-28
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР.....	29-30



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/21

Улиастай

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 18.10 дахь хэсэг, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улс болон орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар хүргүүлсэн төлбөрийн акт, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга болон холбогдох бусад байгууллагуудад хүргүүлэхийг ахлах аудитор (Б.Жалбаа)-д, нээлттэй аудит цахим хуудсаар нийтэд мэдээлэхийг аудитор (Г.Нармандах)-д үүрэг болгосугай.

3. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Б.Жалбаа)-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Болдбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Д.БАТ-УНДРАА



D/Албан бичиг/Тушаал-А/2025
912501020

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХБТХО	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалт
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
НТШЗ	Нээлттэй тендер шалгаруулах зааварчилгаа
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Бодлогын баримт бичигт уялдаагүй харьцуулсан судалгаа	6
2	Дунд хугацааны бодлоготой уялдаагүй төсөл арга хэмжээ	6
3	Богино хугацааны бодлоготой уялдаагүй төсөл арга хэмжээ	7
4	Зураг төсөвгүй батлагдсан ажлууд	9-10
5	Тендер шалгаруулсан 70 төсөл, арга хэмжээг ангиллаар нь харуулсан судалгаа	11
6	ТАХ-ний ХАА-г зохион байгуулсан тоо, төсөвт өртөг, тендерийн хэмнэлт	14
7	Санхүүжилтийн судалгаа	16

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	
Аудитын зорилт	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт арга зүй Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн аудитыг хийж гүйцэтгэсэн. Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд нийцлийн аудит хийн дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж Үндэсний аудитын газарт хүргүүлэхэд аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • <i>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх;</i> • <i>Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх;</i> • <i>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх;</i>
Аудитын хамарсан хүрээ	Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, санхүүжилт, хэрэгжилтийг зохион байгуулсан аймгийн Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагууд, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аудитыг хийж гүйцэтгэсэн.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашигласан.
Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Х.Болдбаатар нар хянан удирдаж, аудитор Д.Пүүжмаа, аудитор Л.Гансүлд нар 2025 оны 03 дүгээр сарын 25-аас эхлэн 2025 оны 05 дүгээр сарын 23-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.
Аудитын мэдээлэл	Аймгийн ИТХ-ийн тогтоолоор орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 122 төсөл арга хэмжээг 16.595.2 сая төгрөгөөр гүйцэтгэхээр баталжээ. Харин орон нутгийн

төсөвт тодотгол хийж 3,855.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл арга хэмжээг хасаж 12,739.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 92 төсөл арга хэмжээг баталсан байна. Төсөл арга хэмжээний 3.519,6 сая төгрөгийн 38 төсөл арга хэмжээг сумдад болон байгууллагад эрхийг нь шилжүүлсэн байна.

БҮЛЭГ 1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГАД БҮРЭН НИЙЦҮҮЛЖ ТӨЛӨВЛӨХГҮЙ БАЙНА

1.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 30.4 хувь нь аймгийн богино болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаагүй төлөвлөгдсөн байна

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд барилга байгууламжийн 7, их засвар тохижилтын 42, тоног төхөөрөмжийн 28, авто зам дэд бүтцийн 11 бусад 4 төсөл нийт 92 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Аудитаар төсөл арга хэмжээг төлөвлөхдөө аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдсан эсэхийг шалгахад аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдсан 11,266.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 73 төсөл арга хэмжээ, Засаг даргын тухайн жилийн үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан 12,987.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 83 төсөл арга хэмжээ байна.

Хүснэгт №1. Бодлогын баримт бичигт уялдаагүй харьцуулсан судалгаа

	Бодлогын баримт бичигтэй уялдсан төсөл, арга хэмжээ	Бодлогын баримт бичигтэй уялдаагүй төсөл, арга хэмжээ	Батлагдсан төсөл, арга хэмжээний тоо	Нийт батлагдсан төсөл, арга хэмжээнд эзлэх хувь
Богино хугацааны бодлогын баримт бичиг	83	9	92	9.8
Дунд хугацааны бодлогын баримт бичиг	73	19	92	20.6
Нийт				30.4

Хүснэгт №2. Дунд хугацааны бодлоготой уялдаагүй төсөл арга хэмжээ

Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Аймгийн бүх нутаг дэвсгэрт хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх	30.0	30.0
Аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнгийн засварын ажлын үлдэгдэл санхүүжилтийг олгох	50.0	50.0
Аймгийн ахмадын сувиллын тоног төхөөрөмж, цагаан хэрэглэлийг шинэчлэх	80.0	80.0
Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газрыг тоног төхөөрөмжөөр хангах	103.0	103.0
Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих	500.0	500.0
Аймгийн Засаг даргын Тамгын газрын компьютер, тоног төхөөрөмжийг шинэчлэх	285.0	285.0

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн загвар төв-ийг түшиглэн "Бизнес инкубатор" төв байгуулах	30.0	30.0
Аймгийн Засаг даргын Тамгын газрыг 00-ыг засварлах	95.0	95.0
Цагаанхайрхан сумын Агьт багт байрлах хөв цөөрмийг засварлаж 100 ш мод тарих	110.0	110.0
Цагаанхайрхан сумын ёслол хүндэтгэлийн өргөөний дээврийг засварлах	15.3	15.3
Тосонцэнгэл сумын ундны усны эх үүсвэрт ус цэвэршүүлэх иж бүрэн төхөөрөмж суурилуулах	140.0	140.0
Тосонцэнгэл суманд ахмадын чуулган зохион байгуулах	30.0	30.0
Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын байгаль хамгаалагчдыг унаажуулах	24.5	24.5
Арц суурийн хилийн боомтод халуун усны барилга барих	110.0	110.0
Хилийн цэргийн 0277 дугаар ангид хөргүүр авах	20.0	20.0
Багийн Засаг дарга нарыг компьютер тоног төхөөрөмжөөр хангах	322.0	322.0
Улиастай сумын хот тохижилт үйлчилгээний албанд хогны машин авах	90.0	90.0
Хот тохижилт үйлчилгээний албаны тоног төхөөрөмжийг сайжруулах	185.0	185.0
Яруу сумын ЗДТГ-ын барилгад их засвар хийх	253.1	253.1

Хүснэгт №3. Богино хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаагүй төсөл арга хэмжээ

	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Аймгийн бүх нутаг дэвсгэрт хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх	30.0	30.0
2	"Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн загвар төв"-ийг түшиглэн "Бизнес инкубатор" төв байгуулах	30.0	30.0
3	Аймгийн Засаг даргын Тамгын газрыг 00-ыг засварлах	95.0	95.0
4	Тосонцэнгэл сумын ундны усны эх үүсвэрт ус цэвэршүүлэх иж бүрэн төхөөрөмж суурилуулах	140.0	140.0
5	Тосонцэнгэл суманд ахмадын чуулган зохион байгуулах	30.0	30.0
6	Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын байгаль хамгаалагчдыг унаажуулах	24.5	24.5
7	Арц суурийн хилийн боомтод халуун усны барилга барих	110.0	110.0
8	Хилийн цэргийн 0277 дугаар ангид хөргүүр авах	20.0	20.0
9	Багийн Засаг дарга нарыг компьютер тоног төхөөрөмжөөр хангах	322.0	322.0

Төсвийг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулаагүй төлөвлөж байгаа нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулах, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоо алдагдах, хууль тогтоомж зөрчигдөх, сөрөг үр дагавартай байгааг цаашид анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Дээрх төлөвлөлт нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх заалт болон Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.17-д "төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим" гэж энэ хуулийн 6.9-д заасан богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг болох улсын болон орон нутгийн төсвийг

төлөвлөхдөө 6.10.3, 6.10.4-т заасан шаардлагыг хангаж Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилан боловсруулахыг” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2. Төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлээгүй, ИТХ-ын төлөөлөгч нар тойрогтоо хөрөнгө оруулалт хийхийг урьтал болгож төсвийг баталж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төсвийн төслийн саналд хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөхдөө судалгаа хийж, нэн тэргүүний чухал ач холбогдолтой төслүүдийг тодорхойлон эрэмбэлж, жагсаалт гарган баримтжуулаагүй байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь сумдуут, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудаас хөрөнгө оруулалтын санал авч байгаа боловч төсөл арга хэмжээг аргачлалаар үнэлдэггүй хэрэгжүүлэх шалтгаан, тулгамдаж буй асуудал, төслөөс гарах үр дүнд нөхцөл байдлын шинжилгээ хийдэггүй байна.

Төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлэх ажлын хүрээнд нийт 500 гаруй ирүүлсэн саналын нэн тэргүүнд шаардлагатай 122 төсөл арга хэмжээний 16,000.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий саналыг аймгийн ИТХ-д хүргүүлж батлуулсан байна

Аймгийн ИТХ-ын төлөөлөгч нар ТЕЗ-ийн ирүүлсэн саналыг батлахдаа иргэдийн санал хүсэлтийг харгалзахгүй сонгогдсон тойрогтоо ямар нэг хэлбэрээр хөрөнгө оруулалт хийхийг урьтал болгож баталж байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах” журмын 2.1.2.23 заалтыг хэрэгжүүлээгүй байна. Төсвийг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулаагүй, ирээдүйд бий болгох үр ашиг, хэрэгцээ шаардлагыг тооцон эрэмбэлэхгүй төлөвлөж байгаа нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулах, зөрчил давтан гарах, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоо алдагдах, хууль тогтоомж зөрчигдөх, ажлын хариуцлага сулрах сөрөг үр дагавартай байгааг цаашид анхаарч ажиллах нь зүйтэй.

Иймд орон нутгийн хэрэгцээ шаардлагын суурь судалгааг жил бүр хийж аймгийг хөгжүүлэх богино, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, ирээдүйд үр өгөөжөө өгөх, орон нутгийн хөгжилд тодорхой дэмжлэг болохуйц төсөл арга хэмжээнд чиглүүлэн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөж байх шаардлагатай байна.

1.3. Зураг төсөлгүй, зураг төсөлд магадлал хийгдээгүй төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд баталдаг, зарим төсөл арга хэмжээний зураг төсвийг ажлыг гүйцэтгэх явцад боловсруулсан байна.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан 92 төсөл арга хэмжээнээс техник, эдийн засгийн үндэслэл болон батлагдсан зураг төсөв шаардагдах 7,383.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 40 төсөл арга хэмжээ байна.

Үүнээс зураг төсөвгүй батлагдсан 4,931.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл арга хэмжээ, зураг төсөв нь хийгдсэн 2,362.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд оруулан баталсан байна.

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Зурагтай эсэх
1	Биеийн тамир, спортын газрын , спорт заалны шалыг шинэчилж засварлах	128	Явцад зураг батлагдсан
2	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын заалыг засварлах	79.8	Явцад зураг батлагдсан
3	Тэс сумын сургуулийн 320 хүүхдийн хичээлийн байрын дулаан алдагдлыг бууруулах	80	зураггүй
4	Тэлмэн сумын соёлын төвийн барилгад их засвар хийх	150	Явцад зураг батлагдсан
5	Завханмандал сумын Хүнгийн голын ногоон хэрмийн бөөрний сувиллыг засварлах	150	зураггүй
6	Тосонцэнгэл суманд камержуулалт хийх	150	зураггүй
7	Улиастай сумын цэвэр, бохир усны шугамыг хэсэгчилж засварлах	120	Явцад зураг батлагдсан
8	Аймгийн Засаг даргын Тамгын газрыг 00-ыг засварлах	95	Явцад зураг батлагдсан
9	Тосонцэнгэл сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх	250	Явцад зураг батлагдсан
10	Баянтэс сумын төвд нийтийн спортын талбай байгуулах	500	зураггүй
11	Завханмандал сумын төвд халуун усны барилга барих	120	Явцад зураг батлагдсан
12	Улиастай сумын гуравдугаар цэцэрлэгийн барилгад их засвар хийх	200	Явцад зураг батлагдсан
13	Аймгийн Хөгжим бүжгийн коллежийн барилгад их засвар хийх	200	Явцад зураг батлагдсан
14	Сантмаргаз сумын ЭМТ-ийн хайсыг шинэчилж, эмч нарын байрыг засварлах	120	Явцад зураг батлагдсан
15	Сантмаргаз сумын нийтийн биеийн тамирын спорт талбайг өргөтгөж засварлах	250	Явцад зураг батлагдсан
16	Нөмрөг сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх	100	зураггүй
17	Цагаанхайрхан сумын Агьт багт байрлах хөв цөөрмийг засварлаж 100 ш мод тарих	110	Явцад зураг батлагдсан
18	Цагаанхайрхан сумын нийтийн спортын талбайг засаж, тохижуулах	70	зураггүй
19	Цагаанхайрхан суманд үндэсний сурын талбай байгуулах	48.6	Явцад зураг батлагдсан
20	Цэцэн-Уул сумын сүмийн булаг, Хар үзүүрийн тариалангийн талбайд ЦДАШ татах	200	зураггүй
21	Шилүүстэй суманд нийтийн биеийн тамирын талбай байгуулах	250	Явцад зураг батлагдсан
22	Их-Уул сумын нийтийн спорт талбайд "Евро" стандартын зүлэг хийх	490	Явцад зураг батлагдсан
23	Тэлмэн сумын хүүхдийн цэцэрлэгт засвар хийх	80	зураггүй
24	Дөрвөлжин сумын спорт заалны дээврийг засварлаж, тоног төхөөрөмжөөр хангах	70	зураггүй
25	Завханмандал сумын төвийн гэр хорооллын дөрвөн гудамжийг гэрэлтүүлэгтэй болгох	50	зураггүй
26	Улаан хаалганы ахмадын сувиллын байрыг засварлах	80	Явцад зураг батлагдсан
27	Отгон сумын соёлын төвийн хуучин барилгыг засварлаж хүний хөгжлийн төв байгуулах	350	Явцад зураг батлагдсан
28	Ургамал сумын ерөнхий боловсролын сургуулийг засварлах	400	зураггүй
29	Их-Уул сумын хоёрдугаар цэцэрлэгийн складны өрөөг тохижуулж шинээр бүлэг байгуулах	40	зураггүй

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, 29¹.2-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх”, 29¹.2.2-д “барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх”, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.2-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй”, 3.2.2.2-д “барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

БҮЛЭГ 2. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАН ҮЗЭХ, ДАХИН ҮНЭЛГЭЭ ХИЙХДЭЭ ХУУЛЬ, ЖУРМЫГ МӨРДӨЖ АЖИЛЛАХГҮЙ БАЙНА.

2.1 Эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт нь хууль, журмын шаардлагад нийцээгүй, баримт бичгийн бүрдүүлэлт дутуу, хяналт тавих хариуцлага сул байна.

“ТБОНӨХБАҮХАТ” хуулийн 44.4-т заасны дагуу Завхан аймгийн Засаг дарга ТЕЗ-ийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, цахим системд нийтэлжээ.

Төлөвлөгөөнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 14,339.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 97 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 56 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын 2.3.2.3-т заасны дагуу холбогдох захиалагч байгууллагуудад шилжүүлсэн байна.

ТЕЗ-ийн эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний 10 буюу 17.9 хувийг хугацаа хоцроон шилжүүлжээ.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан дараах эрхээ доор дурдсаны дагуу шилжүүлж болох бөгөөд энэ талаар гаргасан шийдвэрээ ажлын 5 хоногт багтаан цахим системд оруулж, баталгаажуулна” гэж заасныг зөрчсөн байна.

ХАА-ны тендер шалгаруулалтаас ХААГ-34, эрх шилжүүлсэн бусад захиалагч байгууллага-36 нийт 70 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулж ажилласан байна.

Хүснэгт №5 Тендер шалгаруулсан 70 төсөл, арга хэмжээг ангиллаар нь харуулбал:

	Төсөл арга хэмжээний ангилал	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг
1	Барилга байгууламж	17	4,358.60
2	Авто зам, дэд бүтэц	3	1,570.80
3	Их засвар, тохижилт	23	3,462.90
4	Тоног төхөөрөмж	27	3,353.70

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

	Нийт	70	12,746.00
--	------	----	-----------

(Дэлгэрэнгүй жагсаалтыг аудитын нотлох баримтад хавсаргаав)

Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагаанд мөрдөх хууль, журам, зааврыг бүрэн хэрэгжүүлээгүй, тэдгээрийн хэрэгжилтийг хянах зохион байгуулалт, дотоод хяналтын тогтолцоо хангалтгүй, баримтжуулалт дутуу байгаагаас худалдан авалтын үр нөлөө, ил тод байдал, хариуцлагын зарчим алдагдах эрсдэл үүссэн байна.

Иймд аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг нэгдсэн загвараар боловсруулж, захиалагч байгууллагуудыг арга зүйн удирдлага, жишиг баримт бичгээр хангах нэгдсэн зохион байгуулалтыг хэрэгжүүлэх зөвлөмжийг Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2.2 Тендерийн баримт бичиг, өгөгдлийн хүснэгтийг боловсруулахдаа хэт ерөнхий байдлаар боловсруулж байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын хэрэгжилтийг хангаж, тендерийн урилга нийтлэх, тендер хүлээн авах, үнэлгээ хийх, үр дүнг мэдээлэх хүртэл бүх үе шатанд цахим системээр зохион байгуулан, тендерийн мэдээллийг тухай бүр системд бүртгэж ажилласан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн нийт худалдан авалтыг аргаар нь харьцуулбал:



Эрх шилжсэн зарим төсөл, арга хэмжээний тендерийн гүйцэтгэгчийг шалгаруулахдаа үнэлгээний хороо байгуулаагүй, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл хөтөлдөггүй нь “ТБОНӨХБАҮХАТ” хуулийн 50.2.1, НТШЗ-ны 15.2, 17.1, 17.2, 18.1 дэх заалтуудтай нийцэхгүй байна.

Баримт бичгийн боловсруулалтыг санал хэлэлцэн боловсруулдаггүй, эсвэл шаардлагыг хэт ерөнхий байдлаар өгөгдлийн хүснэгтийг боловсруулж байгаа нь тендерийн ил тод байдал, шударга өрсөлдөөний зарчим алдагдах эрсдэл үүсгэж байна.

Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны хараат бус гишүүнээр тухайн байгууллага болон түүний харьяа нэгжид ажил үүргийн хамаарал бүхий, шууд болон шууд бусаар харьяалагддаг албан тушаалтнуудыг томилсон байна. Энэ нь Сангийн сайдын 2023

оны А/254 дугаар тушаалаар баталсан "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам"-ын 2.4-т заасан хараат бус гишүүнд тавигдах шаардлагатай нийцээгүй байна.

Нийцээгүй төсөл арга хэмжээнээс дурдвал:

- Тэлмэн сумын хүүхдийн цэцэрлэгт засвар-80.0 сая төгрөг
- Тэлмэн сумын соёлын төвийн барилгад их засвар-150.0 сая төгрөг
- Улиастай сумын цэвэр, бохир усны шугамыг хэсэгчилж засварлах-120 сая төгрөг
- Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн дотуур байранд шаардлагатай тоног төхөөрөмж авах-39.0 сая төгрөг
- Улиастай сумын сургуулиудын ойр орчмын авто зам дээр ЛЕД гэрэлтүүлэгтэй явган хүний гарц-37.2 сая төгрөг
- Улиастай сумын дөрөвдүгээр сургуульд цахим танхим байгуулах-50.0 сая төгрөг
- Улиастай сумын тавдугаар цэцэрлэгийн барилгын гадна дулааны шугамыг шинэчлэх-32.0 сая төгрөг
- Атмор байрны хайсыг чөлөөлж, Жинст төгөл хүртэл авто зогсоол хийх-73.5 сая төгрөг
- *Холбооны 27-р байрны баруун талд авто зогсоол хийх-33.5 сая төгрөг Үндэсний сурьт талбайг нэмж тохижуулах-67.4 сая төгрөгийн*
- *Улиастай сумын хот тохижилт үйлчилгээний албанд хогны машин авах-185.0 сая төгрөг*

Дээрх зөрчил нь худалдан авах ажиллагааны үр дүнг бууруулж, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, ашиг сонирхлын зөрчил, авлига хээл хахууль үүсэх нөхцөл бүрдүүлэх, оролцогчдын эрх ашгийг зөрчих эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Иймд "ТБОНӨХБАҮХАТ" хуулийн 50.1-д заасан "Захиалагч энэ хуулийн 10.2-т зааснаар бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаас бусад тохиолдолд үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулна:", Сангийн сайдын 2023 оны А/254 дүгээр тушаалаар батлагдсан "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам"-ын 4.6-д "Үнэлгээний хороо бараа, ажил, үйлчилгээний онцлогоос хамааруулан төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жишиг баримт бичигт нийцүүлэн тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлт, тендер шалгаруулалтын баримт бичигтэй холбоотой тодруулгын төслийг боловсруулж, хууль тогтоомжид нийцүүлэн батлуулахаар захиалагчид хүргүүлнэ", мөн журмын 2.4-д "Орон нутгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан нь тухайн Засаг даргын Тамгын газар, түүний харьяа байгууллагаас зохион байгуулах тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд хараат бус гишүүнээр ажиллахгүй."-заалтуудыг тус тус мөрдөж ажиллах талаар холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2.3 Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгож ажиллах шаардлагатай байна.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 70 ТАХ-ий тендер шалгаруулалтаар 438.8 сая төгрөгийн хэмнэлт гарган ажиллажээ.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Хүснэгт №6 .Тендерийн хэмнэлт нийт төсөл, арга хэмжээгээр

	Төлөв	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Хэмнэлт
1	Хэрэгжсэн	68	12,621.0	12,182.2	438.8
2	Хэрэгжээгүй	2	125.0		
	Нийт	70	12,746.0	12,182.2	438.8

Хэрэгжээгүй 2 төсөл арга, хэмжээ нь 60 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Их-Уул сумын ЭМТ-ийг өргөтгөж шүдний кабинет байгуулах тендерийг 3 удаа зарласан боловч компани тендер ирүүлээгүй, 65 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Нөмрөг сумын ЕБС-ийн анги танхимын ширээ сандлыг шинэчлэх ажлын тендерт шалгарсан Зост-Өргөө ХХК шалгарч гэрээ байгуулах эрх олгосон ч төсөв хүрэхгүй гэх шалтгаанаар гэрээ байгуулаагүй.

Гэрээ байгуулсан гүйцэтгэгчийн тендерийн баримт бичиг, бусад материалыг шалгахад дараах нийтлэг алдаа байна. **Үүнд:**

- Санхүүгийн тайлан баталгаажуулаагүй
- Шаардлага хангахгүй банкны тодорхойлолт
- Татвар, НДШ-н өртэй
- Шаардлагатай хүний нөөц компанийн үндсэн ажилтан гэх боловч компанийн нэр дээр НДШ төлөөгүй
- Өгөгдлийн хүснэгтийг сүүлийн 3 жил ашигтай ажилласан байх гэж боловсруулсан ч шалгарсан гүйцэтгэгч 2 жил ашигтай ажилласан
- Шаардлага хангасан ижил төстэй ажлын гэрээний мэдээллүүд ирүүлсэн боловч хэрэгжүүлсэн ажлын санхүүжилт орсон дансны хуулгыг ирүүлээгүй зэрэг

Аудитаар гэрээ байгуулсан 68 гүйцэтгэгчийн тендерийн баримт бичгийг шалгахад доорх зөрчил илэрлээ.

Үүнд:

- Их-Уул сумын нийтийн спорт талбайд "Евро" стандартын зүлэг хийх ажлын тендерийн шаардлагыг сүүлийн 3 жилд ашигтай ажилласан байх гэж заасан боловч шалгарсан гүйцэтгэгч компани нь баталгаажсан санхүүгийн тайлан дахь ашиг, алдагдлын үзүүлэлтээр сүүлийн 1 жил буюу 2023 онд ашигтай, 2022, 2021 онуудад алдагдалтай ажилласан
- Аймгийн ахмадын сувиллын тоног төхөөрөмж, цагаан хэрэглэлийг шинэчлэх тендерийн санхүүгийн чадавхын шаардлагыг борлуулалтын орлогын хэмжээ 2021,2022,2023 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь багцын батлагдсан төсөвт өртгийн 100 хувь болон түүнээс багагүй байхаар заасан боловч 2021, 2022 оны тайлан баталгаажаагүй, борлуулалтын орлогын хэмжээ тодорхойгүй. Бусад шаардлага хангасан гэх баримт, нотолгоо ирүүлээгүй
- Арц суурийн хилийн боомтод халуун усны барилга барих ажлын тендерийн гүйцэтгэгч нь татварын тайлангийн хэлбэр алдагдалтай, татварын тооцооллын үлдэгдэл 263.7 сая

төгрөг, НДШ-н өглөг 7.5 сая төгрөг, борлуулалтын орлого бусад баримт ирүүлээгүй, түргэн хөрвөх чадварын баримт бичиг шаардлагад нийцээгүй

Үнэлгээний хорооны шийдвэр нь “ТБОНӨХБАҮХАТ” хуулийн 28.1.1-“хамгийн сайн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгох;”, 28.1.3-“шаардлагад нийцээгүй тендер ирүүлсэн оролцогчийн тендерээс татгалзах.”-заалтад нийцээгүй байна. Иймд холбогдох албан тушаалтнуудад албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Тендерийг хянан үзэх, дахин үнэлэхдээ ТБОНӨХБАҮХАТ хууль, журамд нийцээгүй шийдвэр гаргах тохиолдлууд нь тендерт оролцогчдын эрх ашиг зөрчигдөх, маргаан үүсэх, шударга өрсөлдөөнийг хязгаарлах эрсдэлийг дагуулж байна.

Тухайлбал:

- *Нөмрөг суманд тохижилт үйлчилгээний ковш авах ажлын тендер шалгаруулалтад Оттомир ХХК хамгийн сайн тендер ирүүлснээр шалгаруулсанд Монтех дистрибьюшн ХХК Сангийн яаманд гомдол гаргасан бөгөөд Сангийн яам гомдлыг хянаж Оттомир ХХК-ыг шаардлагад нийцсэн хамгийн сайн тендер ирүүлсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй тул шийдвэрийг хүчингүй болгон, үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг даалган шийдвэрлэсэн байна. Мөн үнэлгээг дахин хийхэд өмнө гэрээ байгуулах эрх олгосон Оттомир ХХК-г шалгаруулсан нь хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.3 дахь заалтуудыг зөрчсөн байна.*

Иймд тендер шалгаруулалтыг хянан үзэх болон дахин үнэлэхдээ эрх зүйн зохицуулалт, баримт нотолгоонд тулгуурлах зарчмыг чанд мөрдөж, баримтжуулалтыг сайжруулах, шийдвэр бүрийг үндэслэлтэй, ойлгомжтой, нээлттэй болгох, оролцогч бүх талд тэгш мэдээлэл хүргэх нөхцөлийг бүрдүүлж, шийдвэр гаргалтын процесс дахь оролцогчдын хариуцлагыг тодорхой болгох, аливаа шийдвэр нь гомдол, маргаан үүсгэхгүй байх үндэслэлийг бүрдүүлж ажиллахтай холбогдуулан хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д заасны дагуу холбогдох албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

БҮЛЭГ 3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ САНХҮҮЖҮҮЛСЭН Ч, АШИГЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД ХӨРӨНГИЙГ ДАНС БҮРТГЭЛД БҮРЭН ТУСГАЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн байна.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2024 оны төлөвлөгөөнд их засвар тохижилтын 40 төсөл арга хэмжээ, Барилга байгууламжийн 7 төсөл, арга хэмжээ, Авто зам, дэд бүтцийн 9 төсөл арга хэмжээ, машин техник тоног төхөөрөмжийн 28, бусад төсөл арга хэмжээний 4 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх нийт 13,221.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй төсөл арга хэмжээний зардлын 81.9 хувийг гүйцэтгэгчид шилжүүлсэн байна.

	ТЕЗ	Төсөвт өртөг	Гүйцэтгэгчид олгосон	Зохиогчийн хяналтад олгосон	Барьцааны дансанд төвлөрүүлсэн	Техник хяналтын дансанд төвлөрүүлсэн
1	Завхан аймгийн Засаг дарга	13,789.0	10,829.3	26.8	140.1	76.6

Аудитаар гүйцэтгэгчид олгосон санхүүжилт, техник хяналт, зураг төсвийн үнэ, зохиогчийн хяналтын зардлыг шилжүүлсэн байдлыг дансны хуулгатай тулган шалгахад эрх шилжин хийгдсэн төсөл арга хэмжээний зураг төсвийн үнийг зураг төсвийн эрхгүй аж ахуйн нэгж рүү шилжүүлэх, зохиогч нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн, гэрээний үнийн дүнгээс илүү санхүүжилт олгосон нь зөрчлүүд илэрлээ.

- *Зураг төсөв хийх эрхгүй хувь хүн болон аж ахуйн нэгж рүү зураг төсвийн үнэ шилжүүлсэн / Тэс, Тэлмэн сумд-4.0 сая төгрөг /*
- *Зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж рүү захиалагч хяналт хийх гэрээ байгуулан мөнгө шилжүүлсэн /ХХҮГ-1.3 сая төгрөг/*
- *Гэрээний үнийн дүнгээс илүү шилжүүлсэн /Шилүүстэй, Баянтэс сумдад-2.2 сая төгрөг/*

Дээрх зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

3.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй ажлуудын гэрээг дүгнэж, сунгах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Аймгийн ОНТХО болон сумдад эрх нь шилжүүлсэн нийт 90 төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж, гэрээг дүгнэсэн эсэхийг шалгахад гэрээт хугацааг 4-185 хоног хэтрүүлэн хүлээлгэж өгсөн 3,642.6 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 26 төсөл арга хэмжээ, гэрээний хугацаандаа одоог хүртэл ажил нь дуусаагүй 2,133.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 11 төсөл арга хэмжээний гэрээг сунгаж ажиллаагүй байна.

Үүнд: Ургамал сумын ерөнхий боловсролын сургуулийг засварлах ажлын гэрээ оройтож байгуулагдсан учраас ажил нь хийгдээгүй, гэрээг сунгаагүй байна.



Цагаанхайрхан сумын Агьт багт байрлах хөв цөөрмийг засварлаж 100 ш мод тарих н ажлыг гүйцэтгэгчид 68.3 хувийн санхүүжилт олгосон ч зураг дээрх хийх ажлууд нь дутуу 6

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

машины зогсоол хийгдээгүй, мод тарих ажил хийгдээгүй, цөөрмөө хаших ажлууд тус тус дутуу, гэрээг сунгаагүй байна.



Отгон сумын соёлын төвийн хуучин барилгыг засварлаж хүний хөгжлийн төв байгуулах ажлын санхүүжилтийн 30 хувийг шилжүүлсэн, гэрээний хугацаандаа ажлаа гүйцэтгэж дуусгаагүй



Улиастай сумын 3 дугаар цэцэрлэгийн ажлын санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн,пасадны ажлын дээд хэсэг эргэн тойрон дутуу.



20.0 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн Улиастай сумын хүүхдийн тоглоомын талбайн ажлын санхүүжилтийг бүрэн олгосон ч ажил нь одоог хүртэл хийгдээгүй.



Шилүүстэй суманд нийтийн биеийн тамирын талбай байгуулах ажлын санхүүжилтийн 70 хувийг шилжүүлсэн гүйцэтгэл одоогоор 50 хувьтай байна.



Арц суурийн хилийн боомтод халуун усны барилга барих ажлын төсвийг гүйцэтгэгчид бүрэн шилжүүлсэн, ажлын хэсэг томилогдон ажлыг бүрэн дууссан гэж хүлээж авсан ч дотор талын заслын ажил, цэвэр бохир усны хойлой хийгдээгүй гүйцэтгэл 75 хувьтай байна



Их-Уул сумын хоёрдугаар цэцэрлэгийн складны өрөөг тохижуулж шинээр бүлэг байгуулах ажлын санхүүжилтийн 67.0 хувийг гүйцэтгэгчид шилжүүлсэн, хаалга цонх суулгах шал шахах ажлууд нь хийгдээгүй гүйцэтгэл 80 хувьтай байна.



- Улиастай сумын дөрөвдүгээр цэцэрлэгийн тоглоомын талбайг засварлах ажил
- Улиастай сумын гуравдугаар цэцэрлэгийн барилгад их засвар хийх ажил
- Цагаанхайрхан сумын Агьт багт байрлах хөв цөөрмийг засварлаж 100 ш мод тарих
- Цэцэн-Уул сумын төрийн байгууллагуудыг засварлаж тоног төхөөрөмжөөр хангах ажлын засварын ажил
- Шилүүстэй суманд нийтийн биеийн тамирын талбай байгуулах ажил
- Их-Уул сумын хоёрдугаар цэцэрлэгийн складны өрөөг тохижуулж шинээр бүлэг байгуулах
- Арц суурийн хилийн боомтод халуун усны барилга барих ажил
- Отгон сумын соёлын төвийн хуучин барилгыг засварлаж хүний хөгжлийн төв байгуулах
- Цэцэн-Уул сумын Сумын булаг, Хар үзүүрийн тариалангийн талбайд ЦДАШ татах Ургамал сумын ерөнхий боловсролын сургуулийг засварлах ажлууд гэрээний хугацаанд хийгдээгүй

Иймд ажил нь гэрээний хугацаандаа дуусаагүй гүйцэтгэгчийн гэрээг сунгаж, ажлыг тогтоосон хугацаанд дуусгуулах талаар арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

Энэ нь Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнүүдэд ажлын гүйцэтгэлийн хэдэн хувьд санхүүжилтийг олгох талаар тодорхой тусгаж, “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 2.3.2.4-т заасны дагуу засварын ажил, тоног төхөөрөмж, төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авах комиссын акт, гүйцэтгэгчийн эцсийн санхүүжилт хүссэн албан бичиг, захиалагчийн тооцоог тус тус үндэслэн санхүүжилтийг олгож баримтжуулсан байна гэж заасныг зөрчсөн байна.

3.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад Төрийн аудитын байгууллагаас жил бүр аудит хийж байгаа ч алдаа зөрчил давтагдан гарсаар байна. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг ГХБХБГ болон, сумдын ЗДТГ-ын томилогдсон албан тушаалтнууд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Сумдад эрх шилжсэн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд мэргэжлийн бус сумын ЗДТГ-ын даргын томилсон албан тушаалтнууд хяналт хэрэгжүүлж байгаа нь хяналт хангалтгүй хэрэгжүүлэх үндсэн шалтгаан болж байна.

Тайлант онд газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас 19 барилгын их засвар, гадна талбайн тохижилтын ажилд гэрээний дагуу хяналтыг хэрэгжүүлж, үүрэг даалгаврын биелэлт өгч ажилласан байна.

Мөн Улиастай суманд эрх шилжүүлсэн 4 төсөл арга хэмжээний барилга угсралт, их засварын ажлын явцад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр Улиастай сумын Засаг даргатай гэрээ байгуулсан байна.

Захиалагчийн хяналтын хэрэгжилтийг шалгахад дараах төсөл арга хэмжээнд хяналт хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Улиастай сумын цэвэр, бохир усны шугамыг хэсэгчилж засварлах
- Аймгийн Засаг даргын Тамгын газрыг 00-ыг засварлах
- Завханмандал сумын төвд халуун усны барилга барих
- Сантмаргаз сумын ЭМТ-ийн хайсыг шинэчилж, эмч нарын байрыг засварлах
- Цагаанхайрхан суманд үндэсний сурын талбай байгуулах
- Дөрвөлжин сумын спорт заалны дээврийг засварлаж, тоног төхөөрөмжөөр хангах
- Улиастай сумын долоо дугаар цэцэрлэгийн урлаг заалны барилгыг өргөтгөж засварлах
- Улиастай сумын Үндэсний сурын талбайг нэмж тохижуулах

Мөн хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээг хүлээн авсан комиссоос өгсөн үүрэг даалгавруудыг биелүүлээгүй дараах ажлууд байна.

- Улиастай сумын хэмжээнд нэгдсэн камержуулалт хийх ажлыг эхлүүлэх
- Атмор байрны хайсыг чөлөөлж, Жинст төгөл хүртэл авто зогсоол хийх
- Улаан хаалганы ахмадын сувиллын байрыг засварлах
- Холбооны 27-р байрны баруун талд авто зогсоол хийх

Дээрх үүрэг даалгаврын биелэлт өгөөд хянаагүй, гэрээ байгуулаад хяналтыг хэрэгжүүлээгүй байгаа зөрчилд ГХБХБГ-т албан шаардлага өгөхөөр шийдвэрлээ.

Аудитаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжигдсэн, аймгаас орон нутагт хийгдсэн ажлуудыг шалгахад

- Төсөл арга хэмжээнд мэргэжлийн бус албан тушаалтнууд хяналтыг хэрэгжүүлдэггүй
- Хаана ямар төсөл арга хэмжээ хийгдсэнийг эрх бүхий албан тушаалтнууд нь мэдээгүй
- Ямар байгууллагад төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгүүдийг ашиглуулж байгаа нь тодорхойгүй

байгаа нь чанаргүй барилга байгууламж баригдах, хэт өндөр үнэтэй чанарын шаардлага хангахгүй тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдэх, хөрөнгө үргүйдэх эрсдэл үүссэн байна.

Иймд орон нутагт эрх шилжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг аймагтаа зохион байгуулж, аймгаас орон нутагт хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг сайжруулж ажиллах шаардлагатай байна.

3.4 Ажлыг хүлээж авахдаа комиссын дүгнэлтээр үүрэг даалгаврын биелэлт өгөөд үүрэг даалгаврынхаа биелэлтийг эргээд хянадаггүй алдаа давтан гарсаар байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бүрэн хэрэгжсэн 10,027.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 78 төсөл арга хэмжээг хүлээн авч гэрээг дүгнэн ажилласан байна.

Хөрөнгө оруулалтын санхүүжилт дутуу байгаа нь:

- Дараа онд шилжсэн 1 ажлын 1.071.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй
- Гүйцэтгэл дутуу 3 ажлын санхүүжилтийн 140.1 сая төгрөг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн
- Ажил нь гэрээний хугацаанд дуусаагүй 7 ажлын 991.1 сая төгрөгийг дансанд нь үлдээсэн

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлж, холбогдох хууль журамд нийцүүлэн хүлээн авсан эсэхийг хянаж үзэхэд доорх ажлуудыг комиссын дүгнэлтээр үүрэг даалгаврын биелэлт өгөөд үүрэг даалгаврынхаа биелэлтийг эргээд хянадаггүй алдаа давтан гарсаар байна. Тухайлбал:

- *Улиастай сумын хэмжээнд нэгдсэн камержуулалт хийх ажлыг эхлүүлэх*
- *Атмор байрны хайсыг чөлөөлж, Жинст төгөл хүртэл авто зогсоол хийх*
- *Улаан хаалгын ахмадын сувиллын байрыг засварлах*
- *Холбооны 27-р байрны баруун талд авто зогсоол хийх*

3.5 Гэрээний үнийн дүн нь 1,418.9 сая төгрөг бүхий 6 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн хөрөнгийн шинж чанартай улсын комисс хүлээн авсан 7,313.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 46 төсөл арга хэмжээнээс 2,794.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 26 төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгасан байна.

Харин 1,418.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 6 төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон үндсэн хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Үүнд:

- *Тосонцэнгэл сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх 218.0 сая төгрөг*
- *Цагаанчулуут сумын Цагдаагийн кабоныг халаалтад холбох ажлын 5.5 сая төгрөг*
- *Аймгийн Хөгжим бүжгийн коллежийн дотуур байрны дээврийн их засварын ажил 185.0 сая төгрөг*
- *Сонгино сумын хяналтын цэгт дундаж хурдны улсын дугаар илрүүлэгч LPR хяналтын камер тавих 140.9 сая төгрөг*
- *Их-Уул сумын нийтийн спорт талбайд "Евро" стандартын зүлэг хийх 457.5 сая төгрөг*
- *Улиастай сумын долоо дугаар цэцэрлэгийн урлаг заалны барилгыг өргөтгөж засварлах 336.5 сая төгрөгийн хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгаагүй байна.*

Иймд хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийг ашиглагч байгууллагад нягтлан бодох бүртгэлд тусгуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Хөрөнгийн ашиглалт хамгаалалт, зориулалтын дагуу ашиглаж байгааг шалгахад:

- ХХҮГ-ын Ахмадын сувилалд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж болон цагаан хэрэглэл чанарын шаардлага хангахгүй, одоог хүртэл ашиглагдаагүй байна.
- Багийн дарга нарыг унаажуулахад нийлүүлэгдсэн мотоцикл нь техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтээс зөрүүтэй, чанарын шаардлага хангалтгүй техник тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.
- Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн дотуур байрны гал тогоонд нийлүүлэгдсэн зарим тоног төхөөрөмж чанарын шаардлага хангахгүй, ашиглалтын хугацаанд эвдэрсэн
- Мичид кино театрын хуучин барилгыг 1,200.0 сая төгрөгөөр орон нутгийн өмчид худалдан авсан ч одоог хүртэл хэзээ ашиглах нь тодорхойгүй зэрэг зөрчлүүд ирлээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар чанаргүй тоног төхөөрөмж, хэзээ ашиглалтад орж үр өгөөжөө өгөх нь тодорхойгүй барилга байгууламжийг худалдан авч байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулах эрсдэл үүссэн байна. Иймд дээрх зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Аудитаар 12,836.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж 7.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,914.5 сая төгрөгийн зөрчилд 15 албан шаардлага мөн 170.0 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 9,743.9 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмжийг тус тус хүргүүлээ.

ДҮГНЭЛТ:

1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 30.4 хувь аймгийн богино болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаагүй төлөвлөгдсөн байна.
2. Төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлээгүй, ИТХ-ын төлөөлөөгч нар тойрогтоо хөрөнгө оруулалт хийхийг урьтал болгож төсвийг баталж байна.
3. Зураг төсөлгүй, зураг төсөлд магадлал хийгдээгүй төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд баталдаг, зарим төсөл арга хэмжээний зураг төслийг ажил гүйцэтгэх явцад нь боловсруулсан байна.
4. Эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт нь хууль, журмын шаардлагад нийцээгүй, баримт бичгийн бүрдүүлэлт дутуу, хяналт хариуцлага сул байна.
5. Тендерийн баримт бичиг, өгөгдлийн хүснэгтийг боловсруулахдаа хэт ерөнхий байдлаар боловсруулж байна.
6. Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгож ажиллах шаардлагатай байна.
7. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн байна.
8. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй ажлуудын гэрээг сунгаж ажиллаагүй байна.
9. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байна.
10. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сумд болон байгууллагад эрх шилжигдсэн болон орон нутагт аймгаас хийгдэж байгаа төсөл арга хэмжээнд хяналтыг хэрэгжүүлж ажиллахгүй байна.
11. Ажлыг хүлээж авахдаа комиссын дүгнэлтээр үүрэг даалгаврын биелэлт өгөөд үүрэг даалгаврынхаа биелэлтийг эргээд хянадаггүй алдаа давтан гарсаар байна.
12. Гэрээний үнийн дүн нь 1,418.9 сая төгрөг бүхий 6 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах төсөл арга хэмжээг аймгийн бодлогын баримт бичгүүдтэй бүрэн уялдуулж төлөвлөх, иргэдийн саналыг авч эрэмбэлэх;
2. Төлөвлөлтийн шаардлага хангасан зураг төсөвтэй, олон нийтийн саналыг авч эрэмбэлсэн, ач холбогдол бүхий, үр дүнг тооцсон, төсөл, арга хэмжээг төлөвлөх;
3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд худалдан авч одоог хүртэл ашиглагдаагүй байгаа хэзээ ашиглах нь тодорхойгүй орон нутгийн өмчид бүртгэлтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах арга хэмжээ авах;
4. Хөрөнгө оруулалтаас бий болсон 1,418.9 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагуудын санхүүгийн тайланд бүрэн, үнэн зөв тусгуулах;
5. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний тендер сонгон шалгаруулалт болон ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авах;
6. Сумдад эрх шилжүүлэн хийгдэж байгаа хөрөнгө оруулалтуудын худалдан авах ажиллагааг аймагтаа зохион байгуулах, аймгаас орон нутагт хийгдэж байгаа төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах;

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад:

1. Гүйцэтгэгчтэй байгуулах гэрээг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын холбогдох заалтыг бүрэн тусгаж, гэрээний хугацаанд төсөл арга хэмжээг дуусгахад анхаарч ажиллаж, холбогдох зохион байгуулах болон хяналт тавих үүрэг бүхий албан хаагчдын хариуцлагыг сайжруулах;
2. Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу гаргаж, биелэлтийг 2025 оны 11 дугаар сарын 25-ны өдрийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Байгууллагаас ирсэн санал тайлбар:



**ЗАВХАН АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-26-20
И-мэйл: zavkhan@gazar.gov.mn

2025.05.23 № 150
танай _____ -ны № _____ Т

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн Аудитын тайланд тусгагдсан ажлуудаас Улиастай сумтай хяналтын гэрээ байгуулж хяналтыг хэрэгжүүлж ажилласан. Бусад сумдууд эрх шилжин хийгдсэн ажлуудад ГХБХБГ-аас зөвшөөрөл авч, хяналтын гэрээ байгуулаагүй орон нутагтаа шийдвэрлэсэн.

Улсын комиссоор хүлээн авсан засвар, тохижилтын ажилд гэрээний дагуу хяналтыг хэрэгжүүлж ажилласан болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Э.БАЛЖИННЯМ



812502165



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
И-мэйл: za@zavkhan.gov.mn

2025.05.23 № 315/2
танай _____ -ны № _____ т

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлантай холбоотой саналаа хавсралтаар хүргүүллээ.

Хавсралт хуудастай.

ДАРГА



Т.РЭНЧИНВАНЖИЛ

Doc toot a5

8109090700

**“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ” СЭДЭВТ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН
ТАЙЛАНТАЙ
ХОЛБООТОЙ САНАЛ**

2025.05.23

Улиастай

1. Тайлан болон дүгнэлтийн хэсэгтэй холбоотой санал.

- Тайлангийн хэсэгт Зураг төсөвгүй батлагдсан 4,931.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл арга хэмжээ, магадлал хийгдээгүй 4,608.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 төсөл арга хэмжээ, зураг төсөв нь хийгдсэн 2,362.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд оруулан баталсан байна гэжээ
 - Дээрх зөрчил нь алдаа зөрчлийн нэгтгэл дээр зураг төсөлгүй ажил төлөвлөсөн гэж 5021,4 сая төгрөгөөр тусгагдсан боловч дахин магадлал хийгдээгүй 4608,9 сая төгрөгийн ажил төлөвлөсөн гэж дахцаж орж ирсэн байна. Аль нэг хэсгийг алдаа зөрчлийн нэгтгэлээс хасуулах саналтай.
- Тайлангийн хэсэгт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй ажлуудын гэрээг дүгнэж, сунгах арга хэмжээ авч ажиллаагүй байна гэжээ.

Дээрх 9 ажлаас:

 - Улиастай сумын гуравдугаар цэцэрлэгийн барилгад их засвар хийх ажил
 - Цагаанхайрхан сумын Агьт багт байрлах хөв цөөрмийг засварлаж 100 ш мод тарих
 - Отгон сумын соёлын төвийн хуучин барилгыг засварлаж хүний хөгжлийн төв байгуулах гэсэн ажлууд аймгийн ЗДТГ-тай гэрээ байгуулсан бөгөөд Отгон сумын соёлын төвийн хуучин барилгыг засварлах ажлын гүйцэтгэгчтэй гэрээг сунгаж үлдсэн 2 ажилд гэрээ сунгах, ажил дуусах хугацааг 6-р сарын 15-ны дотор бүрэн дуусгаж комисс ажиллуулах зэрэг шийдвэрүүдийг захиалагчийн зүгээс гарган ажиллаж байна.
 - Үдсэн эрх шилжсэн 6 ажлыг холбогдох эрх бүхий албан тушаалтнуудад мэдэгдэж гэрээг сунган чанартай гүйцэтгүүлэх тал дээр анхаарч ажиллахыг үүрэг болгосон.
- Тайлангийн хэсэгт *Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байна гэжээ.*
 - Цаашид дээрх алдаа зөрчлийг давтаж гаргахгүй байхын тулд эрх шилжүүлэх ажлыг багасгах, холбогдох албан тушаалтнуудыг чадавхжуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Мөн бүх ажил дээр заавал ГХБХБГ-аас эхлэх зөвшөөрөл авч

байна. Мөн бүх ажил дээр заавал ГХБХБГ-аас эхлэх зөвшөөрөл авч ажил эхлүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад чиглэл болгосон.

2. Алдаа зөрчлийн нэгтгэлийн хэсэгт өгөх санал.
 - Сантмаргаз сумын төсвийн төвлөрүүлэн захирагч зураг төсөв хийх эрхгүй аж ахуй нэгж рүү зураг төсвийн үнэ шилжүүлсэн гэж дүгнэн 3,0 сая төгрөгийн акт тогтоосон байна. Дээрх зураг төслийн үнэ өр үүссэн байсан тул өрийг нөхөн төлсөн. Иймээс актын төлбөрөөс хасуулах саналтай.
 - Баянтэс сумын төсвийн төвлөрүүлэн захирагч зураг төсөв хийх эрхгүй хувь хүн рүү зураг төсвийн үнэ шилжүүлсэн гэж дүгнэн 8,0 сая төгрөгийн актын төлбөр тогтоосон байна. Дээрх ажил анх зураг төсөлгүй батлагдсан байсан боловч явц дунд зээлээр зураг төсөл хийлгэж зургийн өрийг барагдуулсан тул актын төлбөрөөс хасуулах саналтай.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2024 оны Орон нутгийн төсвийн Аудитын тайлангийн төсөлд
Худалдан авах ажиллагааны газрын тайлбар

Завхан аймаг дахь төрийн аудитын газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 476 тоот албан бичгээр ирүүлсэн Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд дараах төсөл арга хэмжээнүүдийн талаар ирүүлсэн дүгнэлтэд тайлбар хүргүүлж байна. Үүнд:

Нөмрөг суманд тохижилт үйлчилгээний ковш авах ажлын асуудлаар.

Сангийн яамны 2024 оны 07 дугаар сарын 26-ний өдрийн 03/6271 тоот албан бичгийн дагуу үнэлгээний хороо дахин үнэлж "тус компанийн ирүүлсэн дээрх гэрээ болон баримтууд нь тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д заасан шаардлагад нийцэх эсэхийг нягтлах нь зүйтэй байна" гэж хянасан.


Иймд үнэлгээний хороо нь "Оттомир"- ХХК-ийн ижил төстэй ажлыг худалдан авах ажиллагааны цахим системээр нягтлан үзэхэд шаардлагад нийцсэн ижил төстэй ажлууд хийсэн байсан. Мөн ижил төстэй ажлын гэрээг нотариатаар баталгаажуулан ирүүлснийг үнэлгээнд харгалзаж үзсэн.

"Оттомир" ХХК нь Капитрон банкнаас 2024.06.04-ний өдөр авсан зээлийн мэдээллийн тодорхойлолт, мөн Хаан банкнаас авсан 2024.06.11-ний өдрийн дансны үлдэгдлийн баталгаа ирүүлснийг үнэлгээний хорооны гишүүдийн олонхын саналаар шаардлагад нийцсэн гэж дүгнэж "Оттомир"ХХК-тай гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсэн.

Иймд 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих ажлуудад хийгдсэн Төрийн аудитын тайлангийн дүгнэлтээр ирүүлсэн зөвлөмж, дүгнэлтийг цаашид хэрэгжүүлж ажиллах бөгөөд тус аудитын тайлангийн дүгнэлтийн 14 дүгээр хуудаст тусгагдсан "хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д заасны дагуу холбогдох албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах" хэсгийг зөвшөөрөхгүй байна.

Тайлбар гаргасан:

Худалдан авах ажиллагаа хариуцсан
мэргэжилтэн



С.Түмэнбаяр

Төрийн аудитын газраас шийдвэрлэсэн нь:

Д/д	Ирүүлсэн санал, тайлбар	Төрийн аудитын газрын шийдвэр
Аймгийн засаг даргын санал		
1	Тайлангийн 1.1 дэх хэсэгт Зураг төсөвгүй батлагдсан 4,931.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл арга хэмжээ, магадлал хийгдээгүй 4,608.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 төсөл арга хэмжээ, зураг төсөв нь хийгдсэн 2,362.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд оруулан баталсан байна гэжээ Дээрх зөрчил нь алдаа зөрчлийн нэгтгэл дээр зураг төсөлгүй ажил төлөвлөсөн гэж 5021,4 сая төгрөгөөр тусгагдсан боловч дахин магадлал хийгдээгүй 4608,9 сая төгрөгийн ажил төлөвлөсөн гэж дахцаж орж ирсэн байна. Аль нэг хэсгийг алдаа зөрчлийн нэгтгэлээс хасуулах саналтай гэснийг	Зураг төсөвгүй батлагдсан 4,931.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл арга хэмжээ, магадлал хийгдээгүй 4,608.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 төсөл арга хэмжээ, зураг төсөв нь хийгдсэн 2,362.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд оруулан баталсан байна гэсэн хэсгээс магадлал хийгдээгүй 4,608.9 сая төгрөгийг хасахаар шийдвэрлэв.
2	Тайлангийн 3.2 хэсэгт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй ажлуудын гэрээг дүгнэж, сунгах арга хэмжээ авч ажиллаагүй байна	Аудитын явцад гэрээт хугацаандаа ажлаа гүйцэтгээгүй гүйцэтгэгчтэй байгууллагуудтай гэрээг сунгаагүй байгаа учир энэ саналыг хүлээн авах боломжгүй
3	Тайлангийн 3.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байна.	Энэ алдаа жил бүр давтан гарч байгаа учир тайлангийн хэсгээс хасах боломжгүй.
	Сантмаргаз сумын төсвийн төвлөрүүлэн захирагч зураг төсөв хийх эрхгүй аж ахуй нэгж рүү зураг төсвийн үнэ шилжүүлсэн гэж дүгнэн 3,0 сая төгрөгийн акт тогтоосон байна. Дээрх зураг төслийн үнэ өр үүссэн байсан тул өрийг нөхөн төлсөн. Иймээс актын төлбөрөөс хасуулах саналтай	Өр үүсгэсэн баримтууд ирүүлсэн харгалзан үзэж хасахаар шийдвэрлэв.
	Баянтэс сумын төсвийн төвлөрүүлэн захирагч зураг төсөв хийх эрхгүй хувь хүн рүү зураг төсвийн үнэ шилжүүлсэн гэж дүгнэн 8,0 сая төгрөгийн актын төлбөр тогтоосон байна. Дээрх ажил анх зураг төсөлгүй батлагдсан байсан боловч явц дунд зээлээр зураг төсөл хийлгэж зургийн өрийг барагдуулсан тул актын төлбөрөөс хасуулах саналтай	Зургийг захиалагчаас майлаар ирүүлсэн харгалзан үзэж төлбөрийн актаас чөлөөлөв.
Худалдан авах ажиллагааны газрын санал		
	Тайлангийн 2.2 дахь хэсэгт Сангийн яамны 2024 оны 07 дугаар сарын 26-ний өдрийн 03/6271 тоот албан бичгийн дагуу үнэлгээний хороо дахин үнэлж “тус компанийн ирүүлсэн дээрх гэрээ болон баримтууд нь тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д заасан шаардлагад нийцэх эсэхийг нягтлах нь зүйтэй байна” гэж хянасан.	Сангийн яам 2024.07.26-ны өдрийн 03/6271 дугаартай Гомдол хянасан тухай албан бичгээр “.... тус компанийн тендерээс татгалзсан захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна”, “... холбогдох байгууллагаас нь тодруулж нягталж үзэх нь зүйтэй байна”, “...захиалагчаас тодруулж, хянан үзэх нь зүйтэй байна”, “Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь

Иймд үнэлгээний хороо нь “Оттомир”- ХХК-ийн ижил төстэй ажлыг худалдан авах ажиллагааны цахим системээр нягтлан үзэхэд шаардлагад нийцсэн ижил төстэй ажлууд хийсэн байсан. Мөн ижил төстэй ажлын гэрээг нотариатаар баталгаажуулан ирүүлснийг үнэлгээнд харгалзаж үзсэн. “Оттомир” ХХК нь Капитрон банкнаас 2024.06.04-ний өдөр авсан зээлийн мэдээллийн тодорхойлолт, мөн Хаан банкнаас авсан 2024.06.11-ний өдрийн дансны үлдэгдлийн баталгаа ирүүлснийг үнэлгээний хорооны гишүүдийн олонхын саналаар шаардлагад нийцсэн гэж дүгнэж “Оттомир”ХХК-тай гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсэн.	заалтыг үндэслэн мэдэгдье” гэж шийдвэрлэсэн байна. Үнэлгээний хороо дахин үнэлэхдээ өмнө шалгарсан гүйцэтгэгч болох Оттомир ХХК-г шалгаруулан, Сангийн яам хянасныг харгалзалгүйгээр үнэлгээг хийсэн учир саналыг хүлээн авах боломжгүй.
---	---